



“ХОТ ДЕВЕЛОПМЕНТ” ХК – ИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2020 оны 11 сарын 20-ны өдөр

Дугаар 20/06

Улаанбаатар хот

Г Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус журлыг зуралдуулах тухай Г

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 80 дугаар зүйл, 81 дугаар зүйлийн 81.1.5 дахь заалт, 82 дугаар зүйлийн 82.1.8, 82.1.10, 82.1.11 дахь зүйл, Санхүүгийн Зохицуулах Хорооны “Хувьцаат компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын зөр хүргэх журам”, Компанийн дүрмийн 3.4.5 дахь заалт, “Хот Девелопмент” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн саналыг үндэслэн **ТОГТООХ НЬ:**

1. “Хот Девелопмент” ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус журлыг 2021 оны 01 сарын 04-ний өдрийн 10:00 цагт Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8-р хороо, Залуучуудын өргөн чөлөө 27/1, БиДиСЕК ҮЦК ХК-ийн төв байранд зуралдуулсугай. Коронавирусийн цар төхөлтэй холбогдуулан гэмшгвэс хамгалах бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжсэн тохиолдолд журлыг цахимгаар зохион байгуулсугай.
2. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлаар дараах асуудлуудыг хэлэлцүүлэхээр оруулсугай.
 - Компанийн өрийг хувьцаагаар солих төслийг батлах тухай;
 - Компанийн өрийг хувьцаагаар солихтой холбогдуулан хэвлттэй хуралд нэмж энгийн хувьцаа гаргах тухай;
 - Компанийн өрийг хувьцаагаар солихтой холбоотой сонирхлын зөрчилтэй болон их хэмжээний хэлцлийг хэлэлцэн батлах тухай;
 - Компанийн өрийг хувьцаагаар солихтой холбогдуулан хэвлттэй нэмж гаргаж буй хувьцаанаар тэргүүн ээлжинд худалдан авах эрхийг адлуулах эсэх тухай;
3. Хувьцаа эзэмшигчдийн хуралд оролцох эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалтыг гаргах бүртгэлийн өдрийг “Хурал зуралдуулах тухай зөр”-ыг нийтэд мэдээлсэн өдрөөс хойш 16 дахь өдөр буюу 2020 оны 12 сарын 11-ний өдрөөр тогтоосугай.
4. Компанийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлын зарыг Хэвсрэлт №1-ийн дагуу баталж, нийтэд мэдээлэх өдрийг ТУЗ-ийн шийдвэр гарснаас хойш 5 дахь өдөр буюу 2020 оны 11 сарын 25-ны өдөр Монголын Хөрөнгийн Биржийн цахим хуудсаар болон өдөр тутмын сонингаар мэдээлэх, хурлын зөр мэдээг мэдээлсэн өдрөөс хойш 15 хоногийн дараа буюу 2020 оны 12 сарын 10-ны өдөр анх мэдээлсэн хэлбэрийн дагуу дахин мэдээлэхийг хурал зохион байгуулах комисст даалгасугай.

5. Компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын дэгийг Хавсралт №2-оор баталсугай.
6. Компанийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлаар хэлэлцэх асуудалтай холбогдсон хувьцаа эзэмшигчдийн танилцаж болох бичиг баримтын жагсаалтыг Хавсралт №3-аар баталсугай. Хавсралт №3-д заасан бичиг баримтыг ажлын өдрүүдэд 09⁰⁰-17⁰⁰ цагийн хооронд "БиДиСЕК ҮЦК" ХК-ийн төв оффист ирж танилцах боломжтой.
7. Тус компанийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хуралд оролцох эрх бүхий хувьцаа эзэмшигчдээс хэлэлцэх асуудлаар санал авах "Саналын хуудас"-ын агуулгыг Хавсралт №4-ийн дагуу баталсугай.
8. Үнэт цаасны компаниар дамжуулан хувьцаа эзэмшигчдээс "Санал авах хуудас"-ыг хүлээн авах сүүлийн өдрийг хурал хуралдах өдөр буюу 2021 оны 01 сарын 04-ний өдрийн 10:00 цаг байхаар тогтоосугай.
9. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлыг удирдах хурлын даргаар Д.Даянбилгүүн, хурал зохион байгуулах комиссын даргаар Х.Азбаяр, гишүүнээр Э.Эрхэмзаяа, тооллогын комиссын даргаар Б.Тэмүүлэн, гишүүнээр Б.Даваадорж нарыг тус тус томилсугай.
10. Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлаас гарсан шийдвэрүүдийг хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хуралд танилцуулсугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА



Д.ДАЯНБИЛГҮҮН